



**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2020 оны 11 сарын 23 өдөр

Дугаар A/202

Улаанбаатар хот

□ Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед □
хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйл, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн дүрэм-ийн 10.11.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг компанийн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер /Б.Дашдаваа/, хэлтэс, салбарын дарга, ерөнхий инженер, албадын дарга нарт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.НЯМСАМБУУ

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн
гүйцэтгэх захирлын 2020 оны 11 дугаар сарын
23-ны өдрийн 1102 дугаар тушаалын хавсралт



ХОРИО ЦЭЭР, ХЯЗГААРЛАЛТЫН ДЭГЛЭМИЙН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь гоц халдварт өвчин, цар тахал тархаж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн үед цахилгаан эрчим хүчийг тасралтгүй, найдвартай дамжуулах үүднээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, ажлын цагт зохицуулалт хийх, нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулалтын арга хэмжээг онцгой журмаар шуурхай шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмыг гоц халдварт өвчин, цар тахлын дэгдэлт гарсан нөхцөлд компанийн хэмжээнд мөрдөж ажиллана.
- 1.3. Тухайн орон нутагт хорио цээр, хязгаарлалтын дэглэмд шилжсэн талаар Улсын болон харьяа нутаг дэвсгэрийн онцгой комисс, Онцгой байдлын газраас зарласны дагуу хорио цээр, хязгаарлалтын дэглэмд шилжин гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу компанийн болон салбарын удирдлага, штаб шууд удирдлагаар ханган ажиллана.
- 1.4. Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг сахиулахад шаардагдах хэрэгсэл, нөөцийг бүрдүүлэх ажлыг холбогдох нэгжийн удирдлага зохион байгуулж шийдвэрлүүлж ажиллана.
- 1.5. Компанийн, салбарын удирдлага тусгаарлах байрыг стандартад нийцүүлэн бэлдэнэ.
- 1.6. Ажилтнуудын тоог хамгийн бага түвшинд цөөрүүлэх, шуурхай хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах арга хэмжээг авна.

Хоёр. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед
шуурхай ажиллагааны ажилтнуудад хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 2.1. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед ажиллах ээлжийн хуваарийг компанийн гүйцэтгэх захирал болон салбарын даргын тушаалаар батлуулж мөрдүүлнэ.
- 2.2. Цахилгаан эрчим хүчний хангамжийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүй, урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгах, хойшлуулшгүй ажил гүйцэтгүүлэхэд компанийн шуурхай ажиллагааны ажилтнуудыг уртасгасан цагаар ажиллуулна.
- 2.3. Компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар дэд станцын ээлжийг онцгой графикт шилжүүлэн (24/72 цаг) ажиллуулах ба онцгой нөхцөл байдал үүссэн үед ээлжийн хугацааг уртасгаж болно. Салбарын дарга дэд станцын онцгой графикайг батлан тухайн ажилтанд тухайлсан зааварчилгаа өгч, бичгээр зөвшилцсөн байна.
- 2.4. Дэд станц хоёр ээлжээр ажиллах нөхцөл үүссэн бол компанийн ерөнхий инженерийн шийдвэрээр ээлжийг бүрдүүлэх үүднээс бэлэн байгаа шуурхай

- ажиллагааны ажилтанг дайчлан ажиллуулах арга хэмжээг салбарын ерөнхий инженер авч ажиллана.
- 2.5. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед дэд станцад ажиллах ээлжийн ажилтны хоол хүнс, ариутгал, халдваргүйтгэлийн хэрэгсэл, түлшний хангамжийг 3-аас доошгүй өдрөөр нөөцлөн бэлтгэсэн байна.
- 2.6. Ээлж солилцоход тогтсон зай хэмжээг баримтлан амны хаалт, бээлийг зайлшгүй хэрэглэх, хоорондоо уулзахгүй, мэдээллийг зайнаас болон утсаар солилцоно.
- 2.7. Ээлж хүлээлцэхээс 1 цагийн өмнө станцын хүн хүрсэн, хавьтсан гадаргуу, шалыг 10 литр усанд жавильон 2 ширхэг /таблетка/ уусгаж найруулсан уусмалаар цэвэрлэнэ.
- 2.8. Ээлж хүлээлцсэний дараа 2-4 цагийн дараа цэвэрлэгээг давтан хийнэ.
- 2.9. Ээлжийн хугацаанд дэд станцын чийгтэй цэвэрлэгээг /2.7-д заасан зааврын дагуу/ 1 удаа, агааржуулалт болон агаар сэлгэлтийг 2 цаг тутамд тогтмол хийнэ.
- 2.10. Дэд станцад хийгдсэн халдваргүйтгэл, ариутгал, цэвэрлэгээний талаар тухай бүрт тэмдэглэл хийнэ.
- 2.11. Ажиллах хугацаанд өвчний (халуурах, ханиалгах, цээжээр өвдөх, нус гоожих зэрэг) шинж тэмдэг илэрвэл даруй өөрийгөө тусгаарлан тухайн аймаг, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын утсаар холбогдож, зөвлөмжийн дагуу ажиллана.
- 2.12. Тухайн ээлжинд ажилласан бүх ажилтныг тусгаарлаж шинжилгээнд хамруулна.
- 2.13. Шинж тэмдэг илэрсэн ажилтантай хамт ажиллаж байсан ээлжийн ажилтны ажлыг нэн даруй зогсоож, ажлын байранд 2.7-д заасан цэвэрлэгээ ариутгалыг хийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг мөрдлөг болгон дараагийн ээлжинд ажлыг шилжүүлнэ.
- 2.14. Хавьталд тооцогдож шинжилгээний хариу нь сөрөг гарсан ажилтныг гэрийн тусгаарлалтад 14 хоног байлгаж, бүрэн халдваргүйтгэл хийсний дараа ээлжийн графикт оруулна.
- 2.15. Халдваргүйтгэл, ариутгалд хамрагдсан машин, механизмаар ээлж солилцох ба тогтоогдсон зай хэмжээг баримтлан тээвэрлэнэ. Жолооч нь тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл, ариутгалыг ажлын өдөр эхлэх болон хүн тээвэрлэсний дараа заавар, зөвлөмжийн дагуу хийж, тухай бүрт тэмдэглэл хөтөлж хянуулсан байна.
- 2.16. Ээлжийн хугацаанд гэмтэл саатлын улмаас ажлын байр бэлтгэх зайлшгүй шаардлага гарвал зохих зааврын дагуу нэг удаагийн комбинзон, амны хаалт, бээлийг өмсөн халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж, ажлын байрыг бэлтгэнэ.
- 2.17. Бэлтгэсэн ажлын байранд ажилд оруулахын өмнө болон дараа нь ариутгал заавал хийнэ.
- 2.18. Бригадыг ажилд оруулахад бригадын гишүүн бүр нэг удаагийн комбинзон хувцас хэрэгслийг бүрэн, зөв өмссөн, гарын ариутгалыг хийсэн, биеийн халууныг шалгуулж, зааварчилгаа авсан байна.
- 2.19. Нэг удаагийн комбинзон, бусад хэрэгслийг зөв хэрэглэх, өмсөх, тайлах, хэрэглэсэн эд зүйлийг хогийн саванд зааврын дагуу хаях дараалал, аргачлалын талаар бүрэн ойлголттой байна.
- 2.20. Ашиглалтын болон засварын нөөц бригадыг салбар бүр бүрдүүлж, бэлэн байдлыг хангуулна.
- 2.21. Дэд станцад өдрөөр ажиллах ажилтнууд дээрх дэглэмийг мөрдөнө.

Гурав. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед
оффисын ажилтнуудад хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед өдрийн цагаар ажиллах компанийн төв удирдлага, салбарын ажилтнуудыг ээлжээр ажиллах зохион байгуулалтыг гаргаж, хуваарийг гүйцэтгэх захирлын болон салбарын даргын тушаалаар баталгаажуулан мөрдөж ажиллана.
- 3.2. Өдрийн ажилтны долоо хоногийн ажлын өдөр, ажлын цагийг нөхцөл байдалтай уялдуулан уртасгасан цагаар ажиллуулж болно.
- 3.3. Гэрээс ажиллах өдрийн ажилтан нь холбоо барих утсаа байнга нээлттэй байлгаж, цахим хэлбэрээр ажил үүргээ гүйцэтгэх бөгөөд шууд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу үүрэг даалгаврыг биелүүлж гүйцэтгэлийг тухай бүрт тайлагнаж ажиллана.
- 3.4. Оффист ажиллах хугацаанд ажлын байр, өрөө тасалгаа, ширээ, сандал, компьютер зэрэг байнга хүрэлцдэг гадаргуунд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийг өдөрт 1 удаа хийж, тэмдэглэл хөтлөн хянуулах бөгөөд агаарыг 2 цаг тутамд сэлгэж агааржуулна.
- 3.5. Компанийн болон салбарын удирдлагын өрөө, албан тасалгаа, хурлын танхимд нэвтрэхэд ажилтан амны хаалтыг зүүж, гараа ариутгасан байна. Уулзалт, хурал, зөвлөгөөн дууссаны дараа цэвэрлэгээг тухай бүрт хийнэ.
- 3.6. Ажлын байранд мэргэжлийн байгууллагаас хийгдсэн халдваргүйтгэл, ариутгалын талаар тухай бүрт бүртгэл хийнэ.
- 3.7. Ажилтнууд ажлын байранд амны хаалтыг тогтмол хэрэглэж, хоорондын зайг баримтлан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллана.
- 3.8. Ажилтнууд биеийн халууныг өдөрт 3 удаа хэмжүүлж, асуумжид үнэн зөв хариулж, мэдээлнэ. Гэрээр ажиллах ажилтнууд өөрсдөө биеийн халууныг хэмжих бөгөөд мэдээллийг зааврын дагуу өгч, асуумжид үнэн зөв хариулна.
- 3.9. Оффисын ажилтанд өвчний (халуурах, ханиалгах, цээжээр өвдөх, нус гоожих зэрэг) шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдах албан тушаалтан, холбогдох хяналтын ажилтанд мэдэгдэж, өөрийгөө нэн даруй тусгаарлах байранд тусгаарлан, мэргэжлийн байгууллага, эмчийн заавар, зөвлөмжийг мөрдөнө.
- 3.10. Өвчний шинж тэмдэг илэрсэн ажилтантай хамт ажилласан ажилтнуудын ажлыг нэн даруй зогсоож, дараагийн хуваарьт ажилтанд ажлыг шилжүүлнэ.
- 3.11. Тухайн ээлжинд ажилласан бүх ажилтныг тусгаарлаж, журмын дагуу шинжилгээнд хамруулан мэргэжлийн байгууллага, эмчийн зөвлөмж, зааврыг хэрэгжүүлнэ.
- 3.12. Хавьталд тооцогдон шинжилгээнд хамрагдаж, хариу нь сөрөг гарсан ажилтныг гэрийн тусгаарлалтад 14 хоног байлгаж, халдваргүйтгэлийг бүрэн хийсний дараа ажилд буцаан оруулна.
- 3.13. Халдваргүйтгэл, ариутгалд хамрагдсан машин, механизмаар тогтоогдсон зай хэмжээг баримтлан өдрийн ажилтнуудыг тээвэрлэнэ. Жолооч нь тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл, ариутгалыг ажлын өдөр эхлэх болон хүн тээвэрлэсний дараа заавар, зөвлөмжийн дагуу хийж, тухай бүрт тэмдэглэл хөтөлж, хянуулсан байна.

Дөрөв. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед гэрийн жижүүрийн ажилтнуудад хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 4.1. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед гэрийн жижүүрээр ажиллах реле хамгаалалт, автоматикийн байгууламж, дэд станцын болон агаарын шугамын засварын ажилтнуудыг 3 бүлэгт хуваарилан ээлж бүрдүүлж, гүйцэтгэх захирал болон салбарын даргын тушаалаар баталгаажуулна.
- 4.2. Гэрийн жижүүрээр ажиллах ажилтан нь хуваарьт ажлын өдөр бэлэн байдлыг ханган ажиллах ба түүний нэг өдөрт ажиллах хугацааг ажлын өдрийн цагаар хязгаарлахгүй.
- 4.3. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед гэрийн жижүүр ажилтны нэг удаагийн комбинзон, хувцас хэрэгсэл, хоол хүнс, томилолтын зардлыг 3 өдрөөр бэлтгэн аваарын нөөцөнд бүрдүүлсэн байна.
- 4.4. Засварын бригадын гишүүн нь нэг удаагийн комбинзон, амны хаалт, нүүрний хаалт эсвэл нүдний шил, бээлий зэрэг хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх, зөв өмсөх, тайлах, хэрэглэсэн эд зүйлийг зааврын дагуу хаях дараалал, аргачлалын талаар бүрэн ойлголттой байна.
- 4.5. Цар тахал дэгдсэн нутаг дэвсгэрт байрлах дэд станц болон агаарын шугамд гарсан аваар, саатал, гэмтлийг устгах бригадын бүрэлдэхүүн халдвар хамгааллын дэглэмийг бүрэн сахиж ажиллана.
- 4.6. Гэмтлийг бүрэн устгах хугацаанд бригадын бүрэлдэхүүнийг солихгүй байхаар бүрдүүлсэн байна.
- 4.7. Аваар, саатал, гэмтлийг бүрэн устган засварлаж дуустал бригадын ашигласан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг солихгүй, нэмэлт нөөцтэй байхаар тооцсон байна.
- 4.8. Аваар, саатал, гэмтлийг устгаж, хэвийн горимд шилжүүлэх хүртэл хугацаанд бригадыг буулгахгүй байхаар ажлыг зохион байгуулах ба хооллох, амрах нэмэлт арга хэмжээг төлөвлөсөн байна.
- 4.9. Гэрийн жижүүрийн ажилтанд өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд бусад ажилтнуудаас нэн даруй тусгаарлаж, мэргэжлийн байгууллагын эмчид мэдэгдэх, мэргэжлийн эмчийн заавар, зөвлөмжийг мөрдөнө.
- 4.10. Шинж тэмдэг илэрсэн ажилтантай хамт ажиллаж байсан бригадын ажлыг нэн даруй зогсоож, дараагийн бригадад ажлыг шилжүүлнэ. Энэ үед ашиглаж байсан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахыг хориглоно.
- 4.11. Тухайн бригадын бүх гишүүдийг тусгаарлалтад авч, шинжилгээнд хамруулна.
- 4.12. Хавьталд тооцогдсон ажилтныг шинжилгээнд хамруулж, хариу нь сөрөг гарсан ажилтныг гэрийн тусгаарлалтад 14 хоног байлгах ба бүрэн халдваргүйтгэл хийсний дараа ажилд буцаан оруулна.
- 4.13. Халдваргүйтгэл, ариутгалд хамрагдсан машин, механизмаар ажилтнуудыг тээвэрлэх ба тогтоогдсон зай хэмжээг баримтлан зорчино. Жолооч нь тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл, ариутгалыг ажлын өдөр эхлэх болон хүн тээвэрлэсний дараа заавар, зөвлөмжийн дагуу хийж, тухай бүрт тэмдэглэл хөтөлж, хянуулсан байна.
- 4.14. Гэрийн жижүүрийн бригад нь нэг удаагийн комбинзон хувцас хэрэгсэл бүрэн өмсөн гараа ариутгаж, халууныг шалган зааварчилгаа бүрэн авч ажиллана. Ажлын байр өргөтгөх, сэлгүүцэхийг хатуу хориглоно.